

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо:	2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр
Зээлийн дугаар ба нэр:	L3936: Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл
Гэрээний дугаар ба нэр:	CW03: Замын-Үүд Чөлөөт бүсийн инженерийн дэд бүтэц, барилга байгууламжийн барилгын ажил
Багц 1:	Дулаан, цэвэр усны шугам сүлжээний угсралтын ажил- CW03/1
Багц 2:	Ариутгах татуургын шугам сүлжээний барилга угсралтын ажил- CW03/2
Багц 3:	Цахилгаан, холбооны шугам сүлжээний барилга угсралтын ажил- CW03/3
Тендер хүлээн авах эцсийн хугацаа:	2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 10.00 цагаас өмнө ирүүлнэ.

1. Монгол Улс нь Азийн хөгжлийн банк (АХБ)-аас “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл”-ийг санхүүжүүлэх зорилгоор энэхүү санхүүжилтийг хүлээн авсан бөгөөд уг хөрөнгөөр дээр дурдсан гэрээнүүдийн төлбөрийг санхүүжүүлэх зорилготой болно. Тендер шалгаруулалт нь АХБ-ны эрх бүхий орны тендерт оролцогчдод нээлттэй байна.

2. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичигт заасны дагуу нэг эсхүл хэд хэдэн гэрээ байгуулахаар тендер ирүүлж болно. Тендерт оролцогчид нэгээс дээш гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд үнийн хөнгөлөлт санал болгохыг зөвшөөрөх ба уг үнийн хөнгөлөлтийг тендерийн маягтад тусгасан байна.

3. Монгол Улсын Шадар сайдын ажлын алба (“Захиалагч”) нь эрх бүхий тендерт оролцогчийг CW03: “Замын-Үүд” чөлөөт бүсийн инженерийн дэд бүтэц, барилга байгууламжийн (“Ажил гэх”) ажлын **доорх багц тус бүр болон бүх багцад** барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэх, дуусгах тухай битүүмжилсэн санал ирүүлэхийг урьж байна.

Багц 1: Дулаан, цэвэр усны шугам сүлжээний угсралтын ажил- CW03/1

Багц 2: Ариутгах татуургын шугам сүлжээний барилга угсралтын ажил- CW03/2

Багц 3: Цахилгаан, холбооны шугам сүлжээний барилга угсралтын ажил- CW03/3

4. Нээлттэй өрсөлдөөнт тендер шалгаруулалт (дотоодод зарлан мэдээлэх)-ыг АХБ-ны *нэг үе шаттай: нэг дугуйт* горимын дагуу зохион байгуулах ба тендерийн баримт бичигт заасан эрх бүхий орны бүх тендерт оролцогчдод нээлттэй байна.

5. Энэхүү тендер шалгаруулалтад зөвхөн дор дурдсан чадварын үндсэн шаардлагыг хангасан эрх бүхий тендерт оролцогч оролцоно. Үүнд:

- Сүүлийн 5 (2020, 2021, 2022, 2023, 2024) жилд амжилттай эсхүл үндсэнд нь гүйцэтгэж дуусгасан, мөн санал болгож буй ажилтай ижил төстэй нэгээс доошгүй гэрээт ажилд оролцсон байх, ингэхдээ тендерт оролцогчийн тухайн ажилд оролцсон ажлын үнэлгээ нь: Багц 1: **₮13,900,000,000** (Арван гурван тэр бум есөн зуун сая төгрөг)
Багц 2: **₮1,600,000,000** (Нэг тэр бум зургаан зуун сая төгрөг)
Багц 3: **₮5,800,000,000** (Таван тэр бум найман зуун сая төгрөг)-өөс тус тус доошгүй байна.
- Сүүлийн 3 жилд (2022, 2023, 2024) хэрэгжиж байгаа эсхүл хэрэгжиж дууссан гэрээт ажлын хүрээнд хийгдсэн нийт баталгаат төлбөрийн дүнгээр тооцож гаргасан барилгын ажлын жилийн дундаж борлуулалтын доод хэмжээ:

Багц 1: **₮22,300,000,000** (Хорин хоёр тэрбум гурван зуун сая төгрөг)

Багц 2: **₮ 2,600,000,000** (Хоёр тэр бум зургаан зуун сая төгрөг)

Багц 3: ₮ 9,400,000,000 (Есөн тэрбум дөрвөн зууг сая төгрөг) байна.

Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны дараах тусгай зөвшөөрлүүд шаардлагатай. Үүнд:

Багц 1:

- БА-2.1 Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлт, тохижилтын ажил угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт
- БА-3.3 Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт
- БА-3.4 Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт

Багц 2

- БА-3.3 Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт

Багц 3

- БА-2.1 Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлт, тохижилтын ажил угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт
- БА-3.5 Цахилгаан дамжуулах шугам сүлжээ, дэд станц, түүний тоног төхөөрөмжийн угсралт
- БА-6.4 Барилга байгууламжийн дотор холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн

Эрчим хүчний яамны дараах тусгай зөвшөөрөл шаардлагатай:

- ТЗ-2.2 0.4-35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээний тусгай зөвшөөрлүүдийг шаардана.

6. Дэлгэрэнгүй мэдээлэл авах болон тендерийн баримт бичигтэй танилцах сонирхолтой эрх бүхий тендерт оролцогч нь дараах хаягаар хандана:

Харилцах ажилтан: Ж.Жижгээ, Худалдан авалтын ажилтан

Гудамж: Чингэлтэй дүүрэг, Анкарагийн гудамж, Тод тауэр барилга

Давхар/өрөөний дугаар: 10 давхар, 1001 тоот

Аймаг/хот: Улаанбаатар хот

Улс: Монгол Улс

Утас: 77093936

Цахим шуудангийн хаяг: procurement.mon3936@gmail.com

7. Монгол хэл дээр боловсруулсан тендерийн баримт бичгийг авах хүсэлтэй тендерт оролцогч нь дээр дурдсан хаягт хандан энэ тухай албан хүсэлт гаргаж, үл буцаан олгох нөхцөлөөр тендерийн баримт бичгийн иж бүрдлийг 250,000 (хоёр зуун тавин мянган) төгрөгийн төлбөрийг хийнэ. Төлбөрийн нөхцөл нь Төрийн сан банкны MN650090100900011991 тоот дансанд шууд шилжүүлсэн байна.

8. Тендерийг хүлээн авах эцсийн хугацаа **2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл”, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Анкарагийн гудамж, 4 дүгээр хороо, Тод тауэр барилга, 10 давхар, 1001 тоот өрөөнд** тендерийн баримт бичигт шаардсан тендерийн баталгааны хамт ирүүлнэ. Тендерийг **2025 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 10:10 цагт** нээх ба тендерт оролцогчдын төлөөллийг өөрсдийнх нь хүсэлтээр байлцуулна.

9. Захиалагч нь тендерт оролцогчийн тендер бэлтгэх, хүргүүлэхтэй холбогдсон аливаа зардлыг хариуцахгүй.